

Сургуулийн орчмын хурдны хязгаар гэж юу вэ?

Сургууль орчмын хурдны бүсчлэл гэдэг нь сургуульд нэвтрэх цэгээс 600 футын зайд орших гудамжинд цагт 20 милийн хурдтай явах байнгын хурдны хязгаарлалтыг хэлдэг. Сургууль орчмын энэхүү хурдны шинэ хязгаарлалтын тэмдгүүд нь сургууль орчим явах тээврийн хэрэгслийн хурдын хязгаарлалтыг тодорхой зааж өгөх юм.

Хурдны хязгаарлалтыг бид хаана тогтоож өгсөн бэ?

Хурдны хязгаарлалтын бүсчлэлийг бид төрийн өмчит 11 сургууль мөн хоёр хувийн өмчит сургуулийн хүрээнд тогтоосон. Эдгээр үзүүлэх төслүүдийг бид улс даяар хэрэгжүүлэхийн өмнө тодорхой бүсчлэлүүдэд туршиж үзэх юм.

Үүнийг хэн санаачилсан бэ?

Сургуулийн орчин дахь хурдны хязгаарыг Арлингтон тойргийн тээврийн газрын ажилтнууд Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиуд болон Цагдаагийн Газартай хамтран санаачилсан юм. Санаачлагыг гаргасан ажилтнууд Арлингтон тойргийн Зөвлөлөөс сургууль орчмын хурдны хязгаарлалтыг багасгах энэхүү санаачлагын талаар 2021 оны 11-р сард болох хуралдааныхаа үеэр олон нийтэд мэдээлэх хүсэлтийг гаргаад байгаа юм.

Хурдны хязгаарыг хэзээ хэрэгжүүлэх вэ?

Тойргийн Зөвлөлийн эцсийг шийдвэрээс шалтгаалан энэхүү хурдны хязгаарыг бид 2021/2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Хурдын хязгаарлалтын бүсчлэлээр хурд үнэхээр хязгаарлагдаж буй эсэхийг бид хэрхэн мэдэх вэ?

Бид энэхүү төсөл хэрэгжихээс өмнөх (2021 оны намар) болон дараах (2022 оны хавар) үеийн тээврийн хэрэгслийн хурдны өгөгдлүүдийг судалж энэхүү төсөл хурдны хязгаартай бүсүүдэд (загварчилсны дагуу) амжилттайгаар хэрэгжсэн эсэхийг тодорхойлох юм. Түүнээс гадна 2022 оны хавар явуулсан туршилтынхаа талаарх иргэдийн санал бодлыг бид бас авах болно. Энэ талаар мэдээлэл авахаар бол [Vision Zero website](#) сайтад зочлах буюу сар болгон гаргадаг Мэдээллийн Сониныг захиалаарай.

Бидний амьдарч буй бүх газар сургууль руу очих замаас 600 фут зайд оршдаг → Бүх үед цагт 20 милийн хурдтай явах



Сургууль орчмын хурдыг сайжлуулах нь хүн бүхэнд ач тусмай:

- ◆ Арлингтон дахь дөрвөн ослын нэг нь хурд хэтрүүлсэнтэй холбоотой байдаг.
- ◆ Жил бүр сургууль орчимд 10-аас дээш осол хурд хэтрүүлсэнээ үүдэн гардаг.
 - ◆ Хурд ихсэх тутам хүн гэмтэх үхэх эрсдэл нэмэгддэг.
 - ◆ Хүүхэд бол хамгийн их эрсэлтэй зорчигчдын тоонд ордог.

- Хамрагдсан сургуулиуд:**
- Одоо байгаа бүх гэрэлтүүлгийг сольж ёстой:**
- ◆ Tuckahoe ES + Bishop O'Connell HS (нийлсэн)
 - ◆ Glebe ES
 - ◆ Wakefield HS + Claremont ES (нийлсэн)
 - ◆ St. Thomas More ES + MS
- Эрсдэл Өндөртэй Сүлжээ болон MWCOC-ийн Олон нийтийн газрууд:**
- ◆ Hoffman Boston ES
 - ◆ Gunston MS
 - ◆ Drew ES
- Шинэ Сургуулийн Ажлын Хэсгээс:**
- ◆ Escuela Key ES (өмнө нь Arlington Traditional байсан)
 - ◆ Arlington Traditional ES (өмнө нь McKinley байсан)
 - ◆ Innovation ES (өмнө нь Key байсан)
 - ◆ Cardinal ES

